



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/17

Чингис хот

Гамшгийн аюулын сэрэмжлүүлэг болон
мэдээ, мэдээлэл солилцоход
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.3, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 32 дугаар зүйлийн 32.1.1 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгийн аюулын сэрэмжлүүлэг мэдээллийг иргэдэд багц мессежээр хүргэхэд 1000000 /нэг сая/ төгрөгийг, Гамшгийн үеийн болон урьдчилан сэргийлэх зорилгоор сумдын онцгой комисс, аймгийн гамшгаас хамгаалах албадтай мэдээ мэдээлэл солилцох, цагийн үеийн шуурхай хуралдааныг зохион байгуулахад шаардагдах дүрст хурлын программын жилийн эрхийн төлбөр 800000 /найман зуун мянган/ төгрөгийн хөрөнгийг тус тус зарцуулсугай.

2. Гамшгийн аюулын урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг хүргэх иргэдийн утасны тодотголыг улирал тутам тодотгон ирүүлж байх, багц мессежний нэгжний нөөцийг сумдын Засаг даргын гамшигтай тэмцэх зардлаас бүрдүүлж бэлэн байдлыг хангахыг сумдын Засаг дарга нарт, цаг хугацаанд нь түргэн шуурхай хүргэж ажиллахыг сумдын Засаг дарга, аравтын ахлагч нар, Ус цаг уур орчны шинжилгээний албаны дарга /Л.Чулуун/, Онцгой байдлын газрын дарга /дэд хурандаа Н.Чанцал/ нарт даалгасугай.

3. Дүрст хурлын программын жилийн эрхийн төлбөр, багц мессеж хүргэх хөрөнгийн асуудлыг гүйцэтгэлээр тооцон аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зардлаас тухай бүр шилжүүлж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

231010065